



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 30 өдөр

Дугаар A/386

Мандалговь

Г Аймгийн боловсролын байгууллагын
ажилтан, албан хаагчдын ёс зүйн зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсрол, шинжлэх ухаан, спортын Сайдын 2018 оны A/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам” -ын 2.1, 2.3 заалтуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ**:

1. Боловсролын салбарын ажилтан, албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах зарчим, даган биелүүлэх ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Ц.Мөнхбат (Аймгийн Засаг дарга)
Нарийн бичиг:	Ц.Уранбямба (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
Гишүүд:	С.Алимаа (Сайнцагаан сумын 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч) Д.Мөнхтогтох (Дэрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал) Б.Сүнжидмаа (Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн багш) Д.Дулмаа (Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан) Т.Мөнхбат (Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн нийгмийн ухааны багш) Б.Цэцэг (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн) Б.Энхмандал (Эцэг эхийн төлөөлөл)

2. Аймгийн ёс зүйн зөвлөлд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн A/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг даалгасугай.

3. Энэхүү захирамж ~~батлагдсантай~~ холбогдуулан “Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох тухай” 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн A/393 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4822111251